230001	Эргэж төлөгдөх зээл	18000000.00	82894600.00	240000000.00	152699839.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3181595500.00	2964811906.68	1708432500.00	1423521845.17
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1715172400.00	1715171600.00	0.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1715172400.00	1715171600.00		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	960051800.00	1035164775.00	1161750300.00	1268626797.17
132001	Орон нутгийн төсвөөс	758921900.00	834034875.00	846564600.00	953441089.17
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	201129900.00	201129900.00	315185700.00	315185708.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38586500.00	38586352.00	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38586500.00	38586352.00		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	467784800.00	175889179.68	546682200.00	154895048.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130000000.00	144166779.68	160215000.00	117464548.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53953500.00	31722400.00	33372800.00	37430500.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	283831300.00		353094400.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		153137820.24		193368812.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		193968812.92		144758730.92
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	2.00	2.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	2.00	2.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	134.00	137.00	47.00	24.00
620001	Удирдах ажилтан	13.00	16.00	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	82.00	91.00	9.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	39.00	30.00	2.00	2.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	623.00	904.00	623.00	904.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	622.00	617.00	622.00	617.00
630001	Төрийн өмчит ЕБС	622.00	617.00	622.00	617.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1.00	287.00	1.00	287.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	287.00	287.00	287.00	287.00

Баян-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	134.0	137.0	47.0	24.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00	10.00	10.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3.00	4.00		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16.00	17.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	96.00	97.00	2.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	8.00	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	141680673.00	225859623.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96680673.00	225859623.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96680673.00	196059623.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4000000.00	72730507.00
210101	Үндсэн цалин	4000000.00	58730507.00
210102	Нэмэгдэл		14000000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	500000.00	9040392.00
210201	Тэтгэврийн даатгал	500000.00	8510792.00
210202	Тэтгэмжийн даатгал		132400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		105920.02
210204	Ажилгүйдлийн даатгал		26479.98
210205	Эрүүл мэндийн даатгал		264800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	2411545.00
210302	Түлш, халаалт		2411545.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8150000.00	8572337.00
210401	Бичиг хэрэг		1486976.00
210402	Тээвэр, шатахуун	8150000.00	4747150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		12600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал		1174351.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1151260.00
2105	Нормативт зардал	4000000.00	46548141.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4000000.00	46548141.00

**Баян-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35963753.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9500000.00	
210602	Тавилга	16255000.00	
210604	Урсгал засвар	10208753.00	
2107	Томилолт, зочны зардал	315000.00	296000.00
210702	Дотоод албан томилолт	315000.00	296000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38437300.00	46615300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38437300.00	46615300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5314620.00	9845401.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2434620.00	9845401.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2880000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	29800000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	29800000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		29800000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45000000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45000000.00	0.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45000000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	141680673.00	226771623.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141680673.00	226771623.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93467853.00	41613800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48212820.00	180815908.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4341915.00

3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын санхүүгийн алба нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн албанд дарга-1, мэргэжилтэн-1, нягтлан бодогч -3 нийт 5 орон тоотой ажиллаж байна. Тус суманд төсөвт байгууллага-6, орон нутгийн сан-3 үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-өндөр сумын Төрийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Баян-өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,918.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	307.7	271.2	36.5
Авлага	261.4	425.2	-163.8
Бараа материал	354.3	27.3	327.0
Үндсэн хөрөнгө	5,137.8	2418,7	2,719.1
Нийт хөрөнгө	6,061.2	3,142.4	2,918.8

**Баян-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Өр төлбөр	86.8	1.2	85.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,974.4	3,141.2	2,833.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,061.2	3,142.4	2,918.8

Тайлант онд сумын ОНХСанд 176.0 сая төгрөг, СХСанд 86.7 сая төгрөгийн авлага нэмэгдэж, ЭХСангийн авлага 11.4 сая төгрөг, ЭМТөвийн авлага 86.4 сая төгрөг, ИТХ-ийн авлага 0.08 сая төгрөгөөр, ЕБС-ийн авлага 1.0 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 327.0 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2719.1 сая төгрөгөөр буурсан нь мөн боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр нь ЭМТөв, ИТХ, ЕБС-ийн өглөгөөр буурсан байна.

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 271.2 сая төгрөг болж, өмнөх оноос 36.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0	0	
Банканд байгаа бэлэн мөнгө	307.7	271.2	36.5
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	307.7	271.2	36.5
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	307.7	271.2	36.5

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна. СХСан, ЭХСан ОНӨОрлого, ОНХСан зэрэг байгууллагууд мөнгөн хөрөнгийг үлдэгдэлтэй гарчээ.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 425.2 сая төгрөг болж, өмнөх оноос 163.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1.1	0	1.1
Зээлийн хүүгийн авлага	0.04	2.3	-2.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	85.1		85.1
Татаас санхүүжилтийн авлага	0.3		0.3
Зээлийн хүүгийн авлага	0.9		0.9
Байгууллагаас авах авлага	0.9	48.0	-47.1
Хувь хүмүүсээс авах авлага	173.1	374.9	-201.8
Дүн	261.4	425.2	-163.8

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагыг зээлийн хүүгийн авлага, байгууллагаас авах авлага, хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 27.2 сая төгрөг болж, өмнөх оноос 327.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	80.3	0.1	80.2
Тусгай зориулалттай материал	61.4	0.1	61.3
Эм боох материал	18.9	0	18.9
Дуусаагүй үйлдвэрлэл			
Бэлэн бүтээгдэхүүн			
Хангамжийн материал	273.7	26.8	246.9
Бичиг хэргийн материал	1.4	0.8	0.6
Аж ахуйн материал	6.1	0.4	5.7
Сэлбэг хэрэгсэл	3.1	2.6	0.5
Түлш, шатах тослох материал	2.4		2.4
Барилгын засварын материал	11.2	3.3	7.0
Хүнсний материал	35.7		35.7
Бусад хангамжийн материал	213.8	19.7	194.1
Биологийн хөрөнгө	0.3	0.3	0
Дүн	354.3	27.2	327.1

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 427.4 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.4.4 Биологийн хөрөнгө

Биологийн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3236.0 сая төгрөг болж, өмнөх оноос 3133.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6268.3	3210.1	3058.2
Барилга, байгууламж, орон сууц	4076.3	1541.7	2534.6
Авто-тээврийн хэрэгсэл	264.8	227.8	37.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	550.0	168.9	381.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	219.3	75.0	144.3
Зам, гүүрийн байгууламж	915.6	883.0	32.6
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3.0		3.0
Бусад үндсэн хөрөнгө	172.5	312.7	-140.2
Ном	66.8	1.	65.8
Биет бус хөрөнгө	101.1	25.9	75.2
Программ хангамж	6.7	4.5	2.2
Бусад биет бус хөрөнгө	94.4	21.4	73.0
Дүн	6369.4	3236.0	3133.4

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3,133.4 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой.

Сумын ЗДТГ, ИТХ зэрэг байгууллагууд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 414.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэлд авсан, 13.2 сая төгрөгөөр ном, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэж бүртгэлд тусгажээ.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1.2 сая төгрөг болж, өмнөх оноос 85.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр /
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1.2	0	1.2
Байгууллагад төлөх өглөг	0.5	0	0.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	85.1	1.2	83.9
Дүн	86.8	1.2	85.6

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ЗДТГазар 1.2 сая төгрөгийн өртэй гарчээ.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3141.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2833.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр /
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2011.7	762.5	1249.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	2242.2	2079.4	162.8
Өмнөх үеийн үр дүн	2030.5	5005.4	-2974.9
Тайлант үеийн үр дүн	211.7	-2926.0	-2714.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1720.5	299.2	1421.3
Дүн	5974.4	3141.1	2833.3

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмчийн дүн буурсан нь улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийн эхний үлдэгдлийг зардалд хааснаас тайлант оны үр дүн буурсантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 06/04 тоот тогтоолоор 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1756.3 сая төгрөгөөр баталжээ.

Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 06 тогтоолоор татварын буцаан олголтын дүнг 4.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 241.6 сая төгрөг, татварын бус орлогыг 16.7 сая төгрөгөөр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 427.4 сая төгрөг буюу 65 хувиар давж биелжээ.

Хүснэгт-9

төгрөгөөр

Татварын орлого				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого /ХХОАТ 8.1.1-с бусад	66,822,900	34,921,639.39	31,901,260.61	52.3
ХХОАТ	119,653,700	160,718,826.04	-41,065,126.04	134.3
Хөрөнгийн албан татвар буу	1,710,000	1,765,500	-55,500.00	103.2
Улсын тэмдэгтийн хураамж	1,000,000	742,716	257,284.00	74.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	200,000		200,000.00	0.0
Хог хаягдлын хураамж	5,000,000	4,173,949.9	826,050.06	83.5
Хөрөнгийн орлого / хадгаламж	57,210,000	40,601,988	16,608,012.20	71.0
ан агнуурын орлого		123,456,000	-123,456,000.00	0.0
Газрын төлбөр	2,261,300	1,671,877	589,423.00	73.9
ҮХХАТатвар	1,643,300	2,616,723	-973,423.32	159.2
Хөрөнгө борлуулсны орлого	597,800	12,721,130	-12,123,330.00	2128.0
Татварын буцаалт	-14,472,100	-14,472,044	-55.60	100.0
малд ногдуулах албан татвар	0	49,643,850	-49,643,850.00	0.0
Татварын бус орлого				
хүү торгуул	16,680,000	8,857,000	7,823,000	53.1
Нийт дүн	258,306,900	427,419,155	-169,112,255	165

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн ч улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хөрөнгийн орлого, газрын төлбөр, хүү торгуулийн орлого бүрэн биелэгдээгүй байна.

ХХОАТ, бууны албан татвар, ан амьтны нөөц ашигласны төлбөр, ҮХХАТ, хөрөнгө борлуулсны орлого давсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 72.4 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын захирал, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 1724.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суманд олгох санхүүгийн дэмжлэг буурч, төсөвтөө хасах тодотгол хийсэн ба тэр хэмжээгээр холбогдох зардлууд хэмнэгдсэн байна.

Энэ хуулийн хүрээнд бараа үйлчилгээний бусад зардлыг 68.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баян-Өндөр сумын ТТЗ нь 2022 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар ТТЗ-тай холбоотой зөрчил илрээгүй.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил¹ илэрч, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага гараагүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагуудын ур чадварын нэмэгдлийг улирал тутам ажлын үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулан тухай бүр тогтоож олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 4 байгууллага түүвэрт хамруулсан./ ЗДТГ, ИТХ, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 11.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 5 албан шаардлага, 7.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- **ЗДТГазарт-** Тус байгууллага нь Сумын ЗДТГ-т бүртгэлтэй цахим худгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого аваад бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын ангиллаас худгийн цахилгаан дулаан, засвар үйлчилгээнд зарцуулсан байна. /7.3/
- **ИТХ-д-** Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан 625.0 мянган төгрөгийн тэмдэглэлийн дэвтэр худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.Тэвэр шатахууны зардлыг зарцуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж зарцуулсан
 -2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансанд 2 мэдээлэл байршуулаагүй, 12 мэдээлэл хугацаа хоцорсон, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 227.0 мянган төгрөгийг "Дэвжээ" тэмцээний шагналын санд зарцуулсан
 - Бараа үйлчилгээний бусад зардлаас 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор хамгийн олон мал тоолуулсан малчдад хүндэтгэл үзүүлж 300.0 мянган төгрөгийн цом, сумын тахилгаат уулыг тахих ёслолын арга хэмжээний шагай, морь, бөхийн барилдааны өргөмжлөл, медальд 328.9 мянган төгрөг, аймгийн арслан Лхагваагийн Батсайхан, тус сумаас төрөн гарсан мэргэн харваачид, генерал цолтон, гавьяатнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 704.1 мянган төгрөгийн тус тус зарцуулсан
 - Шилэн дансанд хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 700.0 мянган төгрөгийн 3 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 6313.2 төгрөгийн 1 гүйлгээг дутуу
 - Няравын кассын тайлан гаргаагүй
- **СХСан-** Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хүүгийн өмнөх жилийн орлогоос 675.0 мянган төгрөгийг холбогдох журмын дагуу зарцуулаагүй зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Сант ТТЗ	1	0					1	0					
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР

